



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/385

Улаанбаатар хот

Г Эрүүл ахуй, тархвар судлалын
орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн
бүрэлдэхүүн, ажиллах журам батлах тухай

Эрүүл ахуйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.6 дахь хэсгийг үндэслэн
ТУШААХ нь:

1. "Эрүүл ахуй, тархвар судлалын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг нэгдүгээр, "Эрүүл ахуй, тархвар судлалын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам"-ыг хоёрдугаар, "Монгол Улсын Ерөнхий эрүүл ахуйчийн үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг, хэвлэмэл хуудас"-ны загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тушаалыг холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг Эрүүл ахуй, тархвар судлалын орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн нарийн бичгийн дарга /Ш.Уранцэцэг/-д үүрэг болгосугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



А.ЦОГЦЭЦЭГ

081243

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 10 сарын 06-ны өдрийн
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**Эрүүл ахуй, тархвар судлалын орон тооны бус
мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн**

Зөвлөлийн дарга:

Монгол Улсын Ерөнхий эрүүл ахуйч

Зөвлөлийн нарийн
бичгийн дарга:

Ш.Уранцэцэг, Нийгмийн эрүүл мэндийн газрын
Орчны эрүүл мэнд, эмнэлгийн хог хаягдлын
асуудал хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Д.Баярболд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын
Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга
(зөвшилцсөнөөр)

Б.Баясгалан, Мэргэжлийн хяналтын ерөнхий
газрын Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын
улсын ахлах байцаагч (зөвшилцсөнөөр)

Д.Батдулам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын
Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын
ахлах байцаагч (зөвшилцсөнөөр)

Ч.Гантулга, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын
Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын улсын
ахлах байцаагч (зөвшилцсөнөөр)

А.Амбасэлмаа, Халдварт өвчин судлалын
үндэсний төвийн Тандалт, судалгааны албаны
дарга

И.Болормаа, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний
төвийн Орчны эрүүл мэндийн албаны Эрдэм
шинжилгээний тэргүүлэх ажилтан

Н.Цэрэнбүжид, Зоонозын өвчин судлалын
үндэсний төвийн Лавлагаа лабораторийн тасгийн
эрхлэгч

М.Нэргүй, Нийслэлийн мэргэжлийн хяналтын
газрын Эрүүл ахуй, халдварт хамгааллын хяналтын
улсын ахлах байцаагч (зөвшилцсөнөөр)

Д.Нарансүх, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Орчны эрүүл мэндийн тэнхимиийн эрхлэгч (зөвшилцсөнөөр)

Ч.Цолмон, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш (зөвшилцсөнөөр)

Э.Эрдэнэчимэг, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш (зөвшилцсөнөөр)

Г.Даваа, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш (зөвшилцсөнөөр)

Ч.Үржээ, Монголын эрүүл ахуйч, тархвар судлаачдын нэгдсэн холбооны гишүүн (зөвшилцсөнөөр)

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 10 сарын 25-ны өдрийн
дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**Эрүүл ахуй, тархвар судлалын орон тооны бус
мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрүүл ахуй, тархвар судлалын орон тооны бус мэргэжлийн зөвлөл ("цаашид "Зөвлөл" гэх) нь Эрүүл ахуйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д заасны дагуу эрүүл ахуй, тархвар судлалын асуудлыг хэлэлцэх, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий зөвлөл байна.

1.2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа шударга ёс, хууль дээдлэх зарчмыг сахиж, Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл ахуйн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан болон холбогдох бусад хууль, эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль, тогтоомжийг мөрдлөг болгоно.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт

2.1. Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн газар нь зөвлөлийн ажлын албаны үүргийг гүйцэтгэнэ.

2.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Хуралдааныг зөвлөлийн дарга бөгөөд Монгол Улсын Ерөнхий эрүүл ахуйч удирдана.

2.3. Зөвлөл улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай үед ээлжит бус хуралдааныг мэргэжлийн зөвлөлийн дарга зарлан хуралдуулна. Гишүүдийн ирц гуравны хоёроос дээш хувьтай бол хуралдааныг хүчинтэйд тооцно.

2.4. Зөвлөлийн хуралдааны дэгийг Зөвлөлийн дарга бөгөөд Монгол Улсын Ерөнхий эрүүл ахуйч батална.

2.5. Хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

2.6. Зөвлөл нь "Монгол Улсын Ерөнхий эрүүл ахуйч" гэсэн хувийн дугаар бүхий тэмдэг, хэвлэмэл хуудас" хэрэглэнэ.

2.7. Хуралдааны тэмдэглэлд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурснаар баталгаажна.

2.8. Хуралдаанаас гарсан шийдвэрийг Монгол Улсын Ерөнхий эрүүл ахуйчийн хэвлэмэл хуудсан дээр бичиж, албажуулан холбогдох байгууллагуудад хүргэнэ.

Гурав. Зөвлөлийн эрх, үүрэг

3.1. Зөвлөл нь дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.1.1. Эрүүл ахуй, тархвар судлалын чиглэлээр тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх талаар Засгийн газар, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд мэргэжлийн дэмжлэг үзүүлэн, хамтран ажиллах;

3.1.2. Эрүүл ахуйн нөхцөл, шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс үүдэн хүн амын дунд халдварт өвчин дамжин тархсан, хоолны хордлого, хордлогот халдварын дэгдэлт гарсан зэрэг тохиолдын шалтгаан нөхцөлийг тандан судалж, авсан арга хэмжээний талаарх мэргэжлийн байгууллагын судалгаа, дүгнэлтийг хэлэлцэж, шаардлагатай бол Засгийн газар болон Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад холбогдох байгууллагуудад мэдээллийг хүргүүлж, шийдвэр гаргуулах;

3.1.3. Эрүүл ахуй, тархвар судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Эрүүл мэндийн болон Мэргэжлийн хяналтын байгууллага, төрийн бус байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, тулгамдаж байгаа асуудлаар хамтран ажиллаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлагаар хангах;

3.1.4. Хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, эрүүл ахуй, тархвар судлалын асуудлаар төрийн захиргааны төв болон нутгийн өөрөө удирдах байгууллага, бүх шатны Засаг дарга, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг уялдуулан зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

3.1.5. Эрүүл ахуйч, тархвар судлаачид, лабораторийн шинжээчдийн мэргэжлийн болон хууль эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, тэднийг мэргэшүүлэх, сургалт, семинар, зөвлөлгөөн, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг арга хэмжээг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эрүүл ахуй, тархвар судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулах;

3.1.6. Хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлж буй нь тогтоогдсон бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлохыг түдгэлзүүлэх, хориглох асуудлыг хэлэлцэж, холбогдох байгууллагад хүргүүлж, олон нийтэд мэдээлэх;

3.1.7.Хил дамжин хүнд халдвартлах олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулах өвчний талаарх мэдээлэлд дүн шинжилгээ хийж, авах арга хэмжээний талаар холбогдох байгууллага, мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран ажиллах;

3.1.8.Байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрлэлийн томоохон осол, Нийтийн эрүүл мэндийн ноцтой байдал үүсэж болзошгүй болон үүссэн нөхцөлд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, бэлэн байдлыг хангуулах, хариу арга хэмжээ авах ажлыг холбогдох бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулах, тулгамдсан асуудлыг Эрүүл мэндийн яам, Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

3.1.9.Эрүүл ахуй, тархвар, нян, хор судлалын лабораторийн үйл ажиллагааны чадавхийг дээшлүүлэх, сорилт туршилтыг олон улсын стандартад нийцүүлэх асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

3.1.10.Улсын хэмжээнд дагаж мөрдөх эрүүл ахуй, тархвар судлалын холбогдолтой хууль тогтоомж, хөтөлбөрийн төслийг хэлэлцэж санал өгөх;

3.1.11.Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг эрүүл ахуйн дүрэм, журам, заавар, стандартад заасан хэм хэмжээнд нийцүүлэн, үнэлгээ хийх журам, аргачлалын дагуу үнэн зөв, бодитой хийсэн эсэхийг хэлэлцэж, Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

3.1.12.Эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт болон эрүүл ахуй, тархвар судлалын чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран "Монгол Улсын Ерөнхий эрүүл ахуйч"-ийн Улсын үзлэгийг 4 жил тутамд Аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, дүн, тайлан мэдээг Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүнд танилцуулах.

Дөрөв. Зөвлөлийн даргын эрх, үүрэг

4.1. Зөвлөлийн дарга нь "Эрүүл ахуйн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.7 дахь хэсэгт заасан чиг үүргээс гадна дараахь эрх, үүрэг хүлээнэ.

4.1.1.Зөвлөлийн дарга нь "Монгол Улсын Ерөнхий эрүүл ахуйч" гэсэн үнэмлэх хэрэглэх;

4.1.2.Зөвлөлийн дарга нь зөвлөлийн үйл ажиллагааны тухайн жилийн бодлого, зорилт чиглэлийг тодорхойлон, хийх ажлын төлөвлөгөө, хуралдаанаас гарсан шийдвэрийг баталж, шаардлагатай гэж үзвэл Засгийн газрын болон Эрүүл мэндийн сайдын зөвлөлийн хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

4.1.3. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах төсөв, зардлын тооцоог жил бүр гаргаж, хуралдаанд танилцуулан төсөвт тусгуулах арга хэмжээг авах;

4.1.4. Хуралдааныг зарлах, хуралдааныг удирдах, зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг даалгавар өгч, биелэлтэд нь хяналт тавих;

4.1.5. Зөвлөлийн хагас, бүтэн жилийн ажлын тайланг гаргаж, Эрүүл мэндийн сайдын зөвлөлд танилцуулах, зөвлөлийн гишүүдийн ажлын идэвхи, санаачлага, салбарын болон төр, засгийн шагналд тодорхойлох;

4.1.6. Зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг хууль, тогтоомжийн хүрээнд бий болгох, олон улсын байгууллагын хандив, тусlamжийн дэмжлэг авах;

4.1.7. Зөвлөлийн бодлого, чиглэлийг хангалтгүй хэрэгжүүлж, өгөгдсөн үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй, ажлын хариуцлага, ёс зүйн алдаа гаргасан зөвлөлийн гишүүнийг эргүүлэн татах асуудлыг Эрүүл мэндийн сайдад тавих.

Тав. Зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх, үүрэг

5.1. Хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг зөвлөлийн даргатай зөвшилцэн, батлуулах, хуралдааны бэлтгэл ажлыг хангах;

5.2. Хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан ирүүлсэн баримт бичгийг хүлээн авах, шаардлага хангасан гэж үзвэл хуралдаан болохоос ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд тараах;

5.3. Хуралдааны тэмдэглэлийг баталгаажуулах, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

5.4. Хуралдааны шийдвэрийг шаардлагатай бол хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон нийтэд мэдээлэх;

5.5. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалтын асуудлыг хариуцан ажлын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж хуралдаанд танилцуулах;

5.6. Зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой албан хэргийг хөтөлж, баримт бичгийг холбогдох журмын дагуу архивлах.

Зургаа. Бусад

6.1. Зөвлөлийн ажлын байр, тоног, төхөөрөмж, техникийн бусад үйлчилгээг Эрүүл мэндийн яам хариуцна.

6.2. Зөвлөлийн гишүүд нь Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хариуцлага хүлээнэ.

----оОо----

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 10 сарын 26-ны өдрийн
дугаар тушаалын 3 дугаар хавсралт



**“МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ЭРҮҮЛ АХУЙЧИЙН ҮНЭМЛЭХ,
ХУВИЙН ДУГААР БҮХИЙ ТЭМДЭГ, ХЭВЛЭМЭЛ ХУУДАС”-НЫ ЗАГВАР**

A.Нүүр тал

Б.Дотор тал

СОЁМБО ҮНЭМЛЭХ	МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ Соёмбо ЗУРАГ №... ОВОГ: НЭР: АЛБАН ТУШААЛ: тул үнэмлэх олгов.	Олгосон: оны сарын өдөр олгов. 20... оны сарын ...-ны өдрийг хүртэл хүчинтэй. Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /......./ 20... оны сарын ...-ны өдрийг хүртэл хүчинтэй. Төрийн захиргааны удирдлагын газрын дарга /......./
-------------------------------------	---	---

B. Тэмдэг

Г.Хэвлэмэл хуудас

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ЭРҮҮЛ АХУЙЧ (Монгол бичиг)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ ЭРҮҮЛ АХУЙЧ <hr/> Танай-ны №.....-т ГАРЫН ҮСЭГ
